



## ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

### Гүйцэтгэх захирлын нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулах түр хороо байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Нэр дэвшүүлэх хорооны 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчийг нээлттэй сонгон шалгаруулсан тухай дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг дахин явуулахаар тогтсугай.

2. Нээлттэй Сонгон шалгаруулах түр хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Түр хорооны дарга	Ц.Ариунсанаа	ТУЗ-ийн гишүүн
Гишүүд	Г.Туул	ТУЗ-ийн гишүүн
	Д.Алтангэрэл	ТУЗ-ийн хараат бус гишүүн

3. Түр хороо нь үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллахыг хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

4. Сонгон шалгаруулалтын үр дүнг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг түр хороо (Ц.Ариунсанаа)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА